



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 27 өдөр

Дугаар A-173

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах эрх олгох,
тендер цуцлах тухай

Төрийн болон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.3, Үр тариа, сэлгээний таримлын сорт сорих зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хурлын тэмдэглэл, Тендерийн үнэлгээний хорооны 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 3164 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үр тариа, сэлгээний таримлын сорт сорих зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтын нэгдүгээр багц буюу Төвийн бүсэд үр тариа, сэлгээний таримлын сорт сорих зөвлөх үйлчилгээг 16,000,000.00 /Арван зургаан сая/ төгрөгөөр гүйцэтгэхээр Монголын тариаланчид, гурил үйлдвэрлэгчдийн холбооны ирүүлсэн тендерийг шаардлагад нийцсэн хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосугай.

2. Тендер шалгаруулалтын хоёрдугаар багц буюу Тариалангийн зүүн бүсэд үр тариа, сэлгээний таримлын сорт сорих зөвлөх үйлчилгээг үзүүлэхээр санал ирүүлсэн оролцогчтой хийсэн хэлэлцээ амжилтгүй болсон, хуульд заасан шаардлага хангасан өөр этгээдтэй хэлэлцээ хийж гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлэх технологийн хугацаагүй болсон тул Тариалангийн зүүн бүсэд үр тариа, сэлгээний таримлын сорт сорих зөвлөх үйлчилгээний тендерийг цуцалсугай.

3. Монголын тариаланчид, гурил үйлдвэрлэгчдийн холбоотой гэрээ байгуулах ажлыг шуурхай зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /В.Үнэнбат/-т даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБАЛЦЭРЭН



00000662